
БИНСЭ ХК

**НЭМЖ ГАРГАХ ҮНЭТ ЦААСНЫ
ТАНИЛЦУУЛГА**



Монголын Хөрөнгийн Биржийн Гишүүн



НЭЙШНА СЭКЮРИТИС ХХК

Хаяг: 14252 Улаанбаатар, СБД, Усны гудамж - 1,
Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банкны байр.
Утас: 976-11-331754; 976-9408-1189

АГУУЛГА

АГУУЛГА	2
ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР	4
ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЭЛ.....	5
НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ	
1.1 Үнэт цаас гаргагч компанийн нэр, оршин байгаа хаяг.....	6
1.2 Улсын бүртгэлийн тухай товч мэдээлэл.....	6
1.3 Үнэт цаас гаргагчийн компанийн түүх, хэтийн төлөв.....	6
1.4 Үнэт цаас гаргагч компанийн удирдлага зохион байгуулалтын бүтэц, танилцуулга.....	7
1.5 Үйл ажиллагааны төлөвлөгөө.....	10
1.6 Зах зээлийн судалгаа.....	14
1.7 Үнэт цаас гаргагчийн 5-с дээш хувийн хувьцаа эзэмшигч нар.....	24
1.8 Үнэт цаас гаргагч компанийн эрх бүхий албан тушаалтнууд.....	24
1.9 Үнэт цаас гаргагч компанийн ногдол ашгийн бодлогын талаар.....	24
1.10 Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн болон үнэт цаас бүртгүүлэхийн өмнөх улирлын санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	26
1.11 Үнэт цаас гаргагч компанийн бусадтай байгуулсан их хэмжээний хэлцэл, хууль зүйн хараат бус дүгнэлт.....	27
1.12 Үнэт цаас гаргагч компанийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний талаарх үнэлгээний байгууллагын дүгнэлт.....	28
1.13 Үнэт цаас гаргаж санхүүжүүлэх төслийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэлийн талаарх мэдээлэл.....	29
ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ	
2.1 Үнэт цаасны мэдээлэл.....	30
2.2 Үнэт цаасыг нийтэд санал болгох шийдвэр.....	30
2.3 Үнэт цаас эзэмшигчийн эрх.....	30
2.4 Урьд нь үнэт цаас гаргаж байсан эсэх.....	30
2.5 Үнэт цаас гаргах замаар хуримтлуулах хөрөнгийг зарцуулах төслийн товч танилцуулга, эдийн засгийн үр ашгийн тооцоо.....	31
2.6 Үнэт цаасыг худалдан авснаар хөрөнгө оруулагчдад учирч болох эрсдэл, эрсдлийн шинжилгээ.....	35
2.7 Андеррайтерийн компанийн танилцуулга.....	38
2.8 Үнэт цаасны тухай мэдээлэл, дэлгэрэнгүй танилцуулгатай танилцаж болох газар, хариуцах мэргэжилтэн, холбоо барих мэдээлэл.....	39


ХАВСРАЛТ.....

- Хавсралт 1: Хуулийн компанийн дүгнэлт
- Хавсралт 2: Аудитийн компанийн дүгнэлт
- Хавсралт 3: Хөрөнгийн үнэлгээний тайлан
- Хавсралт 4: Бизнесийн үнэлгээний тайлан
- Хавсралт 5: Андеррайтерийн дүгнэлт



ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо
МХБ	Монголын Хөрөнгийн Бирж
ҮЦГТТХТ	Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн Төв
Андеррайтер	Уг үнэт цаасыг олон нийтэд санал болгох ажлыг гүйцэтгэж буй “Нэйшнл Сэжуритис” ХХК
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
НББ	Нягтлан бодох бүртгэл
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
Төгрөг	Монгол улсын мөнгөн тэмдэгт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
УИХ	Улсын их хурал
ЗГХА	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ДМАЭМБ	Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага
АХЦБӨ	Адууны халдварт. цус багадах өвчих
МЭҮН	Мал эмнэлэг, үржлийн нэгж
МЭЛ	Мал эмнэлгийн лаборатори
МЭҮГ	Мэл эмнэлгийн үржлийн газар
УМЭАЦГЛ	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори
МЭЭСБУЛ	Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори
МЭХ	Мал эмнэлгийн хүрээлэн
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
МЭБС	Мал эмнэлэг биотехнологийн сургууль
МЭҮТ	Мал эмнэлэг үржлийн тасаг
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
МЭМГ	Малын эрүүл мэнд төсөл
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ОУБ	Олон улсын байгууллага
АНУ	Америкийн нэгдсэн улс
ХАА	Хөдөө аж ахуй
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар



ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЭЛ

→ АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИ

“Нэйшнл Сэкиоритис” ХХК

Хаяг: 14252 Улаанбаатар, СБД 3-р хороо, Усны гудамж 1, Үндэсний
Хөрөнгө Оруулалтын Банкны байр.

Утас: 976-11-331754; 976-9408-1189

Вэб сайт: <http://www.nationalsecurities.mn/>

И-мэйл хаяг: info@nationalsecurities.mn

→ ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ КОМПАНИ

“Нэйшнл инвестмент менежмент” ХХК

Хаяг: 14252 Улаанбаатар, СБД 3-р хороо, Усны гудамж 1, Үндэсний
Хөрөнгө Оруулалтын Банкны байр.

Утас: 976-7575-7070

И-мэйл хаяг: info@nim.mn

→ ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИ


“Евиденс Аудит” ХХК

Хаяг: Чингэлтэй, 4-р хороо, Бага тойруу, Зоос гоёл ХК-ны байр, 207
тоот.

Утас: 976-11-323497, 976-99057121, 976-99017537

Факс: 976-11-323497

И-мэйл хаяг: info@evidenceaudit.mn, valuation@evidenceaudit.mn



→ АУДИТИЙН КОМПАНИ

“Сүлд-Аудит” ХХК

Хаяг: Сүхбаатар дүүрэг, Бага тойруу, 8-р хороо, 11-р хороолол, GB
center, 502 тоот

Утас: 976-70118016, 976-99114056

И-мэйл хаяг: gundbayar@suld-audit.mn

Вэб сайт: www.suld-audit.mn

→ ХУУЛИЙН КОМПАНИ

“Билиг Консалтинг” ХХК

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Ж.Самбуугийн гудамж, 19/2-302

Утас: 976-99110914, 976-96961313, 976-99059850

И-мэйл хаяг: o_boroo@yahoo.com

I. ТАНИЛЦУУЛГЫН ЭХНИЙ ХЭСЭГ

I.1 Үнэт цаас гаргагчийн нэр, оршин байгаа хаяг

Нэр: "БИНСЭ" ХК

Хаяг: Монгол улс, Баянгол дүүрэг, 4-р хороо, 2-р хороолол, 018-14 тоот

Утас: 976-8811-3046, 976-8801-5051, 976-11-344740


I.2 Улсын бүртгэлийн товч мэдээлэл

"БИНСЭ" ХК нь анх /регистрийн дугаар 2004917, улсын бүртгэлийн дугаар 3210004001/ нь 2014 оны 09 сарын 2-ны өдөр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн. Үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хавсралтад оруулсан болно.

I.3 Үнэт цаас гаргагчийн түүх, үйл ажиллагааны төрөл, хэтийн төлөв, үйлдвэрлэл үйлчилгээний үндсэн чиглэл, тухайн зах зээлд үнэт цаас гаргагчийн эзлэх байр суурийн талаарх мэдээлэл, судалгаа

"БИНСЭ" ХК нь 2008 онд үүсгэн байгуулагдсан. Санхүүгийн Зохицуулах Хорооны 2014 оны 7 сарын 7-ны өдрийн 269 тоот тогтоолоор "БИНСЭ" ХХК нь "Баянхайрхан" ХК-д нэгдсэн бөгөөд 2014 оны 9 сарын 2-нд "БИНСЭ" ХК оноосон нэртэйгээр Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн.

Зураг 1. Topsurf компанийн малын эм, бэлдмэл




Тус компани нь Монгол улсын хэмжээнд 18 аймагт өөрийн гэрээт борлуулагчаа байршуулж, үүгээрээ дамжуулан мэргэжлийн өндөр түвшинд малын эм бэлдмэл, багаж

хэрэгсэлийг цаг хугацаа алдалгүйгээр мал эмнэлгүүдийг ханган ажиллаж байна. “БИНСЭ” ХК нь өнгөрсөн хугацаанд Монгол орны мал сүрэгт эндемик өвчин буюу эрдэс бодисоос шалтгаалсан өвчин эмгэгийг малчдад таниулж мэдүүлэх чиглэлийг хөгжүүлэх зорилгоор Боловсрол суваг телевизтэй хамтран сургалт сурталчилгааны олон тооны нэвтрүүлгийг бэлтгэн хүргэсэн байдаг. Мөн мал эмнэлгүүдийн аж ахуйг бэхжүүлэх зорилгоор эргэлтийн хөрөнгөөр тасралтгүй хангах ажлыг санаачлан, хэрэгжүүлж байна. Мөн Хөвсгөл аймгийн хэмжээнд мал сүргийг эрүүлжүүлэх зэрэг нийгмийн хариуцлагаа ухамсарласан олон тооны ажлыг санаачлан хэрэгжүүлж байна. Уг компани нь малын эмч нарын залуу халаа болох олон тооны малын эмч мэргэжилтнүүдээс бүрдсэн баг бөгөөд цаашид мал эмнэлгийн салбарт мэргэжлийн түвшинд ажиллаж, салбартаа тэргүүлэх чиглэлийн байгууллага болохоор ажиллаж байна. “БИНСЭ” ХК-ийн үйл ажиллагааны чиглэл болох нь малын эм бэлдмэлийн үйлдвэрлэл, импорт худалдаа эрхлэх юм.

Манай оронд бүртгэлтэй, үйл ажиллагаа эрхэлж буй 40 гаруй эм бэлдмэлийн компани салбарын хэрэглээний 60-70 хувийг хангаж байгаа нь үлдсэн 30-40 хувийн зах зээл байгааг харуулж байна. Компани цаашид үйл ажиллагаагаа эрчимжүүлж, зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлж ажиллахын зэрэгцээ, үйл ажиллагааны хүрээг тодорхойлогч гол зах зээл нь сум, багийн малын эмч, малчдад өөрийн компанийн хувьцааг эзэмшүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Ингэснээр БИНСЭ ХК байнгын худалдан авагчид, тогтвортой зах зээлтэй болох юм.

1.4 Үнэт цаас гаргагчийн зохион байгуулалт, удирдлагын бүтэц, салбар төлөөлөгчийн газрууд, нэгжийн тухай танилцуулга



БИНСЭ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хараат 6 гишүүн, хараат бус 3 гишүүнтэй.

Хүснэгт 1 - ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга - ХЭХ-ийн 2015 оны 03 сарын 26-ны өдрийн 4 тоот шийдвэрээр томилон.

Тамжид овогтой Цогтбаяр – ТУЗ-ийн дарга

1975 онд Өвөрхангай аймгийн Баянгол суманд мэндэлсэн. 1991-1994 онд Хөнгөн үйлдвэрлэлийн техникумийг Ноосон нэхмэлийн технологич мэргэжлээр, 1994-1999 онд Эдийн засаг, математикийн “Хан-Уул” дээд сургуулийг хэрэглээний математикч мэргэжлээр, 2004-2006 онд Тайваний Үндэсний Ченг Кунгийн Их сургуулийг Бизнесийн удирдлагын олон улсын мастераар төгссөн. 1997-1998 онд “Гутал” ХК-ийн үйлдвэртэй хариуцсан дэд захиралын туслал. 1999-2006 онд Монгол Улсын Үнэт цаасны хороо, Хяналт шалгалтын хэлтэст Ахлах мэргэжилтэн, 2006-2008 онд “Жас групп” ХХК

стратегийн газарт Төлөвлөлтийн албаны дарга. 2007-2008 онд “Мослак” ХХК Төслийн ахлах менежер, 2008-2010 онд “Эф Си Икс” ХХК Андеррайтер, брокерийн компанид Гүйцэтгэх захирал, 2010-2011 онд “Опстра Эф Икс” ХХК-д хөрөнгө оруулалтын зөвлөх. 2011 оноос өнөөг хүртэл “Үндэсний хөрөнгө оруулалтын банк”-ны бизнес хөгжлийн газрын захирал. 2012 оноос өнөөг хүртэл “НэйшнлИнвестмент Менежмент” ХХК-ийн гүйцэтгэх захиралаар тус тус ажиллаж байна. Удирдлага, Үнэт цаасны зах зээлд олон жилийн ажлын туршлагатай. Англи хэлийг маш сайн эзэмшсэн.

Сүхбаатар овогтой Ганбат – ТУЗ-ийн гишүүн

1974 онд Баянхонгор аймагт мэндэлсэн. 1993-1998 онд Улаанбаатар хотын ХААИС-ийн Мал эмнэлэгийн сургуулийг Малын их эмч мэргэжлээр бакалаврын зэрэг, 2007 онд Удирдлагын академид суралцан мэргэжил дээшлүүлсэн. 1998 оноос одоог хүртэл “Мандраа” ХХК-ийн Гүйцэтгэх захиралын албан тушаалыг нэр төртэйгээр хашиж, малын эмч мэргэжлээрээ ажиллаж байна.

Баатар овогтой Отгонбаяр – ТУЗ-ийн гишүүн

2002 онд ХААИС-ийн, Мал эмнэлэг Биотехнологийн сургуулийг Малын их эмч мэргэжлээр бакалаврын зэрэг хамгаалж төгссөн. 2007-оос 2010 онд “Цагаанзалаа агвет” ХХК, Технологич, 2008-2013 онд “БИНСЭ” ХХК-ийн Үйлдвэрлэлийн албаны дарга. 2014 оноос одоог хүртэл “Малын эмч нарын залуу үе холбоо” ТББ-ийн Тэргүүнээр тус тус ажиллаж байна. Мал эмнэлэгийн салбарт 8 жилийн туршлагатай. Англи хэлтэй.

Чойжилжав овогтой Оюунцэцэг – ТУЗ-ийн гишүүн

1960 онд Говь-Алтай аймагт мэндэлсэн. 1978-1984 онд Улаанбаатар хотын ХААИС-ийн Мал эмнэлэгийн сургуулийг Малын их эмч мэргэжлээр бакалаврын зэрэг хамгаалж төгссөн. 1984-1990 онд Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Малын эмч, 1990-2000 онд Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Малын эмч, 2000-2011 онд “Хөвсгөл Хүлэг” ХХК-д Ерөнхий менежер, 2011 оноос одоог хүртэл “Хөвсгөл Хүлэг” ХХК-д Малын эмчээр ажиллаж байна. Монгол улсын Мал эмнэлгийн салбарт 30 жил ажилласан арвин туршлагатай нэгэн юм. Түүний нөр их хөдөлмөрийг үнэлж, төр засгаас Хөдөө Аж Ахуйн тэргүүний ажилтан цол тэмдэгээр шагнаж байжээ.

Мэнджаргал овогтой Адилбиш – ТУЗ-ийн гишүүн

1979 онд Улаанбаатар хотод мэндэлсэн. 1996-2001 онд Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Мал эмнэлэг Биотехнологийн Их Сургуулийг Малын их эмч мэргэжлээр төгссөн. 2001-2004 онд “JCS” ОУБ-ын Vet Нет төслийн малын их эмч, төслийн зохицуулагчаар ажилласан. 2004-2012 онд “Монгол Ви.И.Ти.Нет” ТББ-ын гүйцэтгэх захирал 2012 оноос өнөөг хүртэл “Батмэнд сүрэг” ХХК-ийн захиралын албан тушаалд ажиллаж байгаа.

Мэргэжлийнхээ чиглэлээр АНУ, Англи улсуудад мэргэжил дээшлүүлсэн. Мал эмнэлгийн салбарт 14 жилийн туршлагатай.

Цэндбазар овогтой Өлзийбаяр – ТУЗ-ийн гишүүн


1986 онд Өвөрхангай аймагт мэндэлсэн. 2004-2007 онд СУИС-ийг найруулагч мэргэжлээр, 2005-2006 онд МҮОНРТ-ийн хөтлөгчийн сургалтанд сууж Хөтлөгчийн ур чадвар эзэмшсэн. 2007-2010 онд Боловсрол суваг телевизэд хөтлөгч редактор, 2010 оноос өнөөг хүртэл “Боловсрол суваг” телевизийн хөдөө аж ахуй хариуцсан “Өрлөг” студийн захиралаар ажиллаж байна. 2010 онд Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс “Малч ухаан”, “Ажлын амт” зэрэг нэвтрүүлгээрээ “Ган үзэгтэн” шагнал хүртсэн юм. Англи хэлтэй.

Цэрэндорж овогтой Алтансүх – ТУЗ-ийн хараат бус гишүүн

1978 онд Булган аймагт мэндэлсэн. 1996-2001 онд ХААИС-ийн Мал эмнэлэг биотехнологийн сургуулийг Малын их эмч мэргэжлээр бакалавр зэрэг хамгаалан төгсчээ. 2001-2003 онд ХААИС магистрантур, 2009 оноос БНХАУ-н Жи Лин Их сургуульд докторантур, 2003-2009 ХААИС-МЭБСургуулийн багш, 204 оноос өнөөг хүртэл “Их-Азар” ХХК-ийн захирал, 2011 онд өнөөг хүртэл “Эх Ачиут” ХХК-ийн Гүйцэтгэх захиралаар тус тус ажиллаж Барилгын яамны хүндэт жуух бичигээр шагнагдсан байна. Англи, Хятад хэлтэй.

Жүгдэр овогтой Өлзийбаяр – ТУЗ-ийн хараат бус гишүүн

1983 онд Хөвсгөл аймагт мэндэлсэн. 2001 онд Хөвсгөл аймгийн Их Уул сумын 10 жилийн дунд сургуулийг төгссөн. 2006 онд Улаанбаатар хотын ХААИС-ийн Мал эмнэлэг биотехнологийн сургуулийг Малын их эмч мэргэжлээр бакалавр зэрэг хамгаалан төгсчээ. Хөвсгөл аймгийн Их уул сумын малын эмчээр ажилладаг.



Цэнгэл овогтой Өнөржаргал – ТУЗ-ийн хараат бус гишүүн

2010 онд Удирдлагын академийг Удирдахуйн ухааны докторантаар төгссөн. 2012 онд “Компанийн засаглалын сургагч багш бэлтгэх сургалт”-нд хамрагдсан. 2009 онд БНХАУ-ын Эдийн засгийн хөгжлийн асуудлууд сургалтанд оролцсон. 1999-1997-1999 онд Чоно травел компанид аялал жуулчлалын менежер, 1998-1999 онд Залуучуудын Аялал Жуулчлалын төвийн захирал, 2006 онд МИУ ОУДС-д төслийн удирдагч, ерөнхий менежер, төлөвлөлтийн албаны даргаар, 2006 оноос одоог хүртэл Удирдлагын академийн Менежментийн тэнхимийн ахлах багшаар ажиллаж байна. Удирдлагын онол, Аялал жуулчлалын чиглэлээр 14 эрдэм шинжилгээний бүтээл нийтлүүлсэн. 2014 онд Удирдлагын академийн эрдэм шинжилгээний илтгэлийн 2-р байр, 2013 онд Ерөнхий сайдын Талархалын бичиг зэрэг 10 гаруй гавьяа шагналыг хүртсэн туршлагатай нэгэн

ЮМ.

“БИНСЭ” ХК-ийн гүйцэтгэх захирлаар Төлөөлөн Удирдах Зөвлөлтэй байгуулсан гэрээний үндсэн дээр Б.Батзаяа ажиллана. Б.Батзаяа нь 1984 онд мэндэлсэн. Хөдөө Аж Ахуйн Их Сургууль, Мал эмнэлэг- Биотехнологийн сургуулийг Малын их эмч мэргэжлээр төгссөн. Тэрээр 2008 онд малын эм бэлдмэлийн үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр “БИНСЭ” ХХК-г үүсгэн байгуулж, нэгдэх хүртэл Ерөнхий захирлаар ажиллаж ирсэн. Энэ хугацаандаа 2009 онд малын эрүүл мэнд, Малын эмч нарынзалуу үе холбоо “ТББ”-г байгуулж, 2009-2010 онд гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. Компани нь үндсэн 6 ажилтантай байх бөгөөд үүнд, Гүйцэтгэх захирал-1, Нягтлан бодогч-1, Ерөнхий менежер-1, Бүс хариуцсан борлуулалтын менежер-3 гэсэн бүрэлдэхүүнтэй ажилладаг.

Диаграм 1. Удирдлага, зохион байгуулалтын бүтэц



1.5 Үйл ажиллагааны төлөвлөгөө

1.5.1 Компанийн зорилго, зорилтууд

Эрхэм зорилго

Монгол улсын нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамарсан малын эм бэлдмэл, мал эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэлтийн сүлжээг бий болгон, хэрэглэгчдэд хүртээмжтэй, чанартай, орчин үеийн шаардлагад нийцсэн бэнчмарк бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэж ажиллах:

Зорилтууд

- ✓ Бүсчилсэн хангамжийн агуулах байгуулах:

- ✓ Бусад малын эм үйлдвэрлэгч болон импортлогч компаниудтай хамтран ажиллаж, бүтээгдэхүүнийг зуучлан борлуулах;
- ✓ Улс орон даяар малын эмийн худалдааны онлайн сүлжээг бий болгох;

1.2 Бүтээгдэхүүн, Үйлчилгээ, Үйлдвэрлэл, Түүхий эд материал

Канадын Topsurf Inc компанийн Монгол дахь албан ёсны төлөөлөгчбөгөөд тус компанийн БНХАУ-ийн Нанжин хот дахь үйлдвэрээс бүтээгдэхүүнээ татан авч, малчдад нийлүүлж байна. Нанжин Вэтоп Фарм ХХК нь Хятад улс дахь малын эм үйлдвэрлэлийн тэргүүлэгч үйлдвэр юм.

Үйлдвэрлэлийн бүхий л шат дамжлагууд нь GMP журмын дагуу явагддаг. Үйлдвэрлэлийн 4 шат дамжлагатай. Тус компани нь эхний бүтээгдэхүүнээс эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргах явцдаа чанарын хяналтыг ханган ажиллах үүднээс мэргэжлийн лабораториар тоноглогдсон, өндөр мэргэжлийн туршлагатай ажиллах хүчнээр хангагдсан байгууллага юм.

Тус үйлдвэр нь Судалгаа хөгжүүлэлтийн 100 ажилтан, чанарын хяналтын 15 ажилтантай бөгөөд бүх ажиллагсад нь мэргэжлийн тусгай зөвшөөрөл, гэрчилгээтэй. Нанжин Вэтоп Фарм ХХК-ийн бүтээгдэхүүнүүд нь БНХАУ-ын аймаг мужуудад маш сайн борлогддог. Мөн Африк, Ойрхи Дорнод, Латин Америк болон дэлхийн бусад улсуудад өөрийн зах зээлд амжилттайгаар өргөжүүлэн ажиллаж байна.



Хүснэгт 2. Бүтээгдэхүүний танилцуулга

Бүтээгдэхүүний нэр

Бүтээгдэхүүний танилцуулга

ТОРСА-Р50




Бэлчээрийн маллагаатай манай оронд өвөл, хаврын улиралд мал сүрэг кальци болон фосфорийн дутагдалд маш ихээр орж, ядрах, сульдах, сүүний гарц муудах, ясны төрөл бүрийн эмгэгт өртөн, турж эцэх гэх мэт олон хүчин зүйл бий болдог. Иймд үүнээс урьдчилан сэргийлэх, эмчлэх зориулалтай бүтээгдэхүүн юм.

Торолуу 20LA



Бактерийн гаралтай хамрын хөндийн үхжилт үрэвсэл. Үе мөчний үрэвсэлт эмгэгүүд (сохор догол). Дэлэнгийн үрэвсэл. Сав, үтрээний үрэвсэл. Бактерийн гаралтай нүдний үрэвсэл. Амьсгалын замын үрэвсэлүүд (уушгины үрэвсэл). Хүйн халдварын үрэвсэл. Арьсны халдварт үрэвсэлийн эмчилгээнд хэрэглэдэг.

Topenistrep 20/20




Амьсгалын зам, шээс дамжуулах зам, тэжээл боловсруулах замын халдвар, дэлэнгийн үрэвсэл, савны үрэвсэл, давсагны үрэвсэл ясны сөнөрөл, гэдэсний түгжрэл, цусны үжил болон бактерийн гаралтай хоёрдогч халдварын үед адуу, үхэр, хонь, ямаа, гахайг эмчлэхэд хэрэглэнэ.

Topenicillin Ia




Бактерийн гаралтай мал амьтны уушигны үрэвсэл (томуу, ханиад), сав үтрээний үрэвсэл, чоно нохойд ургуулсан болон бусад шарх, адууны сахуу өвчний үед тарьж хэрэглэнэ.

TOPMEC 1%




Малын гадна, дотно шимэгчийн эсрэг өргөн хүрээний үйлчилгээтэй тарилгын шингэн.

TOP-ANTI-DIARRHEE



Мал амьтны ходоод гэдэсний архаг, цочмог салстын халдвар, чацга алдалт, хоол тэжээлийн хордлого, гэдэсний дүүрэнги, мал амьтны ходоод гэдэсний халдвар, уушигны халдвар, эндометрит, чих нүдний халдварын үед хэрэглэнэ.

TOPALBEN



Албендазол нь мал, амьтны нематод, цестод, трематодын бүлгийн дотоод шимэгч хорхойн эсрэг сонгомол үйлчилгээтэй бэлдмэл

TOP Ca+Mg




Бэлдмэлийн найрлага дахь кальци, магни нь бие мах бодид магний дутагдлыг нөхөж булчингийн хүч чадлыг нэмэгдүүлэх, элэгний үйл ажиллагааг дэмжиж уураг, нүүрс ус, ӨӨХ тосны багадалтаас сэргийлэн бие мах бодийн өсөлт, дархлааг сайжруулна.

BILVES




Селен болон E витаминь зохистой харьцаагаар хольсон бэлдмэл юм. Селен нь амьдын жинг нэмэгдүүлэх булчингийн өсөлтийг хангах үүрэгтэй бөгөөд E витамин нь үхэр хонины биед зайлшгүй шаардлагатай тосонд уусдаг витамин юм.

TOP CYPER




Хачиг, хамууны хачиг, хувалз, ширх, нохой бөөс болон паразитуудын авгалдай хэлбэр мөн төрөл бүрийн шавжны эсрэг хэрэглэнэ.

Циперметрин нь бүх төрлийн шавж, хүнсний ногоо, жимсний хортон шавж, хөвөнгийн цагаан эрвээхэй гэх зэргийн шавжуудын устгалд өргөн ашиглагддаг ХАА-н инсектицид юм. Мөн түүнчлэн хүнсний агуулах, хүлэмж, нисэх онгоц, автомашин, автобус, үйлдвэрийн барилгад төрөл бүрийн шавж, хортон шавжны устгалд хэрэглэдэг.




Гик Стоп



Стрептомицин болон пенициллинд мэдрэмтгий нянгаар үүсгэгдсэн халдварт өвчний үеийн эмчилгээнд хэрэглэнэ. Тухайлбал: Амьсгалын зам, шээс дамжуулах зам, тэжээл боловсруулах замын халдвар, дэлэнгийн үрэвсэл, савны үрэвсэл, давсагны үрэвсэл ясны сөнөрөл, гэдэсний түгжрэл, цусны үжил болон бактерийн гаралтай хоёрдогч халдварын үед адуу, үхэр, хонь, ямаа, гахайг эмчлэхэд хэрэглэнэ.

Топ витаминЕ



Витамин Е селен дутагдах өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэнэ. Бодисын солилцоо алдагдах, үр хөврөлийн өсөлт хөгжилт буурах, булчин цайх өвчний үед, булчингийн гэмтэл, зүрхний үйл ажиллагаа сулрах, өсөлт хөгжилт зогсох үед тус тус хэрэглэнэ.

Топтилозин




Топтилозин нь үхэр, хонь, ямаа, гахай, тахианд булчинд гарихад зориулагдсан антибиотикийн бэлдмэл юм. Тухайлбал:

Үхрийн дэлэнгийн үрэвсэл, савны идээт үрэвсэл, цусан суулга, Амьсгалын замын халдварын үед, халуурах нус гоожих, хамар битүүрэх, ханиалга, амьсгаадах, уушгиний мөгөөрсөн хоолойн үрэвсэл, уушгиний сүрьеэ, гахайн халдварт атропик ринит, өсөлт удаашрах, идэш тэжээлийн дуршил буурах, Тугалын үе мөчний үрэвсэл, уушиг цагаан мөгөөрсөн хоолойн үрэвсэл, Хонь ямааны сохор догол, Томуу, хамрын хөндийн сөнөрөлт үрэвсэл, Гахайн дэлэнгийн болон савны үрэвсэл, цусан суулга, Гахайн арьсны үрэвсэл.


Малын эм бэлдмэлээс гадна доорх төрлийн багаж хэрэгслийг мал эмнэлгүүдэд нийлүүлдэг.




Ган зүү 12 (16G, 17G, 18G)




Автомат тариур 10 мл (иж бүрэн)




Ган зүү 16G,17G,18G




Автомат тариур 50 мл (иж бүрэн)




Автомат тариур 5 мл (иж бүрэн)




Автомат тариур 5 мл (иж бүрэн)



Автомат туулга олгогч 5 мл



Автомат туулга олгогч 10 мл



1.5.3 Үндсэн хоронго, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл

Компани ирэх 1-2 жилийн хугацаанд дахин нэмж хувьцаа гаргах замаар 2 тэрбум хүртэлх төгрөгийг татан төвлөрүүлж, зүүн, баруун, төвийн бүсийг хамарсан эм ханган нийлүүлэх орчин үеийн агуулах 5-г барьж байгуулахаар төлөвлөж байна. Үүнтэй зэрэгцэн технологийн орчин үеийн шийдэл ашиглан онлайн-аар захиалга хүлээн авах, бүртгэлийн системийг бий болгохыг зорьж байна.



1.6 Зах зээлийн судалгаа

1.6.1 Монгол улсын мал аж ахуйн салбар

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг. Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.


Монгол улсын эдийн засгийн гол үндэс болсон хөдөө аж ахуйн салбар нь 2010 оны байдлаар улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 15.9 хувь, экспортын орлогын 12.5 хувийг хөдөө хөдөө аж ахуйн салбар бүрдүүлж нийт ажиллах хүчний 33.5 хувь нь энэ салбарт ажиллаж байна. Нийт хөдөө аж ахуйн салбарын дотор 80.2 хувийг зөвхөн мал аж ахуйн салбараас үйлдвэрлэж байна.

График 1. Бүртгэгдсэн малын тоо /мян/



Салбарын бүтцээр анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүн дотроо мал аж ахуйн салбар 1999 он хүртэл ДНБ-ий 30-40 орчим хувийг үйлдвэрлэж, 2000 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин буурч, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувийн жин өссөөр байна.

График 2. Мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэл /сая.төгрөгөөр/



Хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэл эдлэл үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болсоор байна.




1.6.2 Монгол улсын мал эмнэлгийн салбар

ДМХЭМБ-аас 2007, 2010, 2012 онуудад хийсэн үнэлгээгээр нийт 5 оноо авахаас манай орны мал эмнэлгийн байгууллагын үйл ажиллагаанд 1.8 онооны үнэлэлт өгч цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэл, стратегийг тодорхой болгох талаар анхаарч ажиллахыг тус байгууллагаас зөвлөсөн.

Малын халдварт, халдваргүй, паразит өвчнөөр 2008-2012 онд нийт 704.0-1047.0 мянган мал өвчилсөн бол мал эмнэлгийн арга хэмжээний чанар сайжирч, хүртээмж нэмэгдсэнээр сүүлийн 5 жилийн байдлаар өвчний гаралт буурах хандлагатай байна.

График 3. Өвчилсөн малын тоо



Мал эмнэлгийн эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 2012 онд малын халдварт боом, цусанхалдварт, дуут, сохор догол, шөвөг яр, гахайн мялзан, адуу тэмээний томуу, хонь, ямааны цэцэглэхайн мялзан зэрэг 28 нэрийн нян болон вирус, микоплазмаар үүсдэг өвчнөөс сэргийлэх вакцин, эмчилгээний зориулалт бүхий 5 нэрийн хэт дархлаат ийлдэс, оношлуурын цомог болох антиген, өвчтэй, эрүүл ийлдэс, хавсрага, гемолизин зэрэг 26 нэрийн биобүтээгдэхүүн нийт 59 нэрийн 31.6 сая малыг вакцинжуулахад хүрэлцэхүйц хэмжээтэй 3.1 тэрбум төгрөгний үнэ бүхий 134022 литр шингэн, 10640.3 мянган тун хатаасан бэлдмэл бүтээгдэхүүн, 28 нэрийн 450.0 сая төгрөгийн үнэ бүхий оношлуур, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн мэргэжилтнүүдийн давтан сургалт 851.0 сая, ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээнд 703.0 сая, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн бүтээгдэхүүн өвчинтэй тэмцэх арга хэмжээнд нийт 35.1 сая малыг вакцинжуулж 11.3 тэрбум төгрөг, АХЦБӨ-өөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 5 аймаг, сүрьеэ, лейкоз өвчнөөс эрүүлжүүлэний баталгаа гаргах арга хэмжээнд 8 аймгийн 3.1 сая малыг хамруулахаар 12.4 тэрбум төгрөгийг, гоц халдварт шүлхий өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтанд 3.2 тэрбум, МЭҮН-ийн чадавхийг бэхжүүлэхэд 1.6 тэрбум, гоц халдварт, халдварт өвчний тандалт шинжилгээ хийхэд 522.8 сая, МЭЛ-ийг орчин үеийн өндөр мэдрэмж бүхий тоног төхөөрөмж, хашаа, биоаюулгүй ажиллагааны чадавхийг сайжруулах, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэврийн магадлан шинжилгээнд олон улсын хэмжээний нийтлэг аргыг нэвтрүүлж, бүтээгдэхүүний экспорт, импортын аюулгүй байдлыг хангах, мал сүргийг дархлаажуулах ажлын чанарыг лабораторийн түүвэр шинжилгээгээр тогтоох, үнэт аргаар урьдчилан сэргийлэх ажлын үр дүнсэйжруулах зэрэг зардалд нийт 24,489,665.0 мянган төгрөгийг төлөвлөж хэрэгжилтийг зохион байгуулсан.

СЭА
БҮРТГЭВ
№ 01

График 4. Мал эмнэлгийн арга хэмжээ дэх санхүүжилт (сая.төгрөг)





График 5. Санхүүжилтийн бүтэц



1.6.5 Бизнесийн хууль эрх зүйн орчин


“Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль” (2001.06.07 болон 2007.11.16 өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан), “Гамшигтай тэмцэх тухай хууль” (2003.06.20), “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” (2005.12.01), Малчдын талаас төрөөс баримтлах бодлого (УИХ-ын 2009 оны 34-р тогтоол), “Монгол мал” Үндэсний хөтөлбөр (УИХ-ын 2010 оны 25-р тогтоол), “Эм, эмнэлгийн хөрөнгийн тухай хууль” (1998.05.07, 2006.01.05, 2010.05.20), “Малын гоц халдварт өвчний оношийг баталгаажуулах, хорио цээр хязгаарлалтын бүс тогтоох, уг бүсэд үйл ажиллагаа явуулах журам” (Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 305-р тогтоол) “Мал эмнэлэг, ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээ олгох журам”, “Өлөн гэдэс бэлтгэх, хүлээн авах үеийн мал эмнэлэг, ариун цэврийн шаардлага”, мал амьтны халдварт өвчинтэй тэмцэх заавар зэрэг хууль, дүрэм, журмыг гарган мөрдүүлсэн нь мал эмнэлгийн ажил, үйлчилгээг зохицуулах эрх зүйн орчин болно.

Мал эмнэлгийн салбарт МЭҮН, мал эмнэлгийн зориулалттай эм, вакцин, оношлогоо, өвчний үнэний арга хэрэглэх арга зүйтэй холбоотой нийт 252 стандарт, малын халдварт, паразитгах өвчинтэй тэмцэх, сэргийлэх 66 заавар батлагдан одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

“Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжийн” МNS 5368 1, 2, 3 : 2011 стандарт 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөж эхэллээ.

Мал эмнэлгийн ажил, үйлчилгээг улсын хэмжээнд төлөвлөлт, шуурхай зохицуулалтын асуудал хариуцсан ЗГХА-МЭҮГ, халдварт, гоц халдварт болон бусад өвчний оношлогоо, шинжилгээ хийх үүрэгтэй УМЭАЦТЛ, манай оронд хэрэглэж байгаа малын эм, биобэлдмэл хэрэгсэлийн эрэлт шаардлагад нийцсэн шинжилж, үнэлгээ, дүгнэлт гаргадаг МЭЭСБУЛ, мал эмнэлгийн салбарын шинжлэх ухааны судалгаа, эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэдэг МЭХ, “Биокомбинат” төрийн өмчит үйлдвэрийн газар, ХААИС-ийн МЭБС, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн алба, лаборатори, 329 төрийн МЭҮТ, хувийн хэвшлийн 879 МЭҮН өөр өөрийн эрх, үүргийн дагуу хариуцан ажилладаг.

Малын эмийн талаарх бодлого нь “Эмийн талаар төрөөс баримтлах бодлого”, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” хууль, “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай” хууль, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хууль, “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хууль, “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль, “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулиуд, “Мал эмнэлгийн зориулалттай эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох лиценз” зэрэг эрх зүйн актын хүрээнд Малын эмийн салбар зөвлөлийн үйл ажиллагаагаар зохицуулагддаг.



Мал эмнэлгийн эмийн болон үйл ажиллагааны чиглэлээр мөрдөгдөж байгаа 260 гаруй стандарт /фармакопей/, ХХААХҮЯ-ийн сайдын тушаалаар батлагдсан Малын эмийн салбар зөвлөлийн ажиллах журам, малын эм бүртгэлийн дүрэм, мал эмнэлгийн зориулалттай эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох лиценз зэрэг эрх зүйн актын хүрээнд Малын эмийн салбар зөвлөлийн үйл ажиллагаа зохицуулагдаж байна.

Малын эмийн болон Мал эмнэлгийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн талаар төрөөс баримтлах бодлогын үзэл баримтлал боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Мал эмнэлгийн салбарт хэрэгжиж буй олон улсын төсөл, хөтөлбөр

Дэлхийн банк болон Европын холбооны улсын санхүүжилттэй “Шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчинтэй тэмцэх чадавхийг сайжруулах” төсөл

Дэлхийн банк, Европын холбоо, Засгийн газар хамтран “Шувууны томуу, хүний томуугийн цар тахалтай тэмцэх чадавхийг сайжруулах” төслийн зорилго, зорилтыг амжилттай хэрэгжүүлж, Монгол улсад хүний томуу, шувууны томуу өвчний бэлэн байдлын чадавхийг бий болгож чаджээ.

Төслийн эхний үе шат амжилттай хэрэгжсэн ба дараагийн үе шатны төслийг Дэлхийн банк, Монгол Улсын Засгийн газар хамтран 2012 оны 12 дугаар сараас эхлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Төслийн төлөвлөлтийн асуудлаар мал эмнэлгийн салбарын техникийн дэвнэг хэргийг байгуулан ажилд нь оруулсан ба мал эмнэлгийн салбарт 1.2 сая долларын бараа, ажил, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөгдөөд байна.

Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй Малын эрүүл мэнд төсөл

ДМАЭМБ-ын Ерөнхий чуулганаар баталсан “Хуурай газрын мал амьтны эрүүл мэндийн кодексе”-ын зохих заалтын дагуу Монгол улсын баруун 7 аймгийн нутаг дэвсгэрийг “Шүлхий өвчнөөр тайван, вакцин таригдаагүй бүс” болгон ДМАЭМБ-аар албан ёсоор зарлуулах зорилгоор шаардлагатай баримт бичгийг нэмэлт боловсруулалт хийх, Монгол улсад шүлхий, бруцеллөзтэй тэмцэх, сэргийлэх Үндэсний стратеги бодовсруулахад “Мал аж ахуй”-н төслийн шугамаар Швейцарийн Холбооны Улсын SAFOSO болон бусад зөвлөхтэй гэрээ хийж Монголд урьж мэргэжлийн туслалцаа үзүүлсэн болно.

ЗГХА МЭҮГ, МЭМТ-ийн ажилтан нарын 5 хүний бүрэлдхүүнтэй баг 2012 оны 06 дугаар сард Тайландын Бангкок хотноо ДМАЭМБ/НҮБ ХХААБ-аас хамтран зохион байгуулсан шүлхийн тэмцэх дэлхийн II удаагийн хуралд оролцсон. Хурлын үеэр ДМАЭМБ/НҮБ ХХААБ шүлхийтэй тэмцэх шаталсан арга хэмжээний талаар хэлэлцэж, шүлхий өвчний дэлхий дахины нөхцөл байдал, өвчний улмаас учирч байгаа нийгэм, эдийн засгийн үр нөлөө, бүс нутагт шүлхийг хяналтанд авах талаарх санал санаачлага, вакцинжуулалт өвчинлөөгөө арга аргачлалын өнөөгийн байдал, судалгааны талаар шинжээчид илтгэл тавьж, хуралд оролцогчид санал бодлоо солилцсон.

ЗГХА МЭҮГ-ын хүсэлтээр өнгөрсөн оны 09-12 дугаар сарын хугацаанд долоо хоног тутамд мал эмнэлгийн эпидемиологийн тусгайлсан семинарыг УМЭАЦТЛ дээр төслийн зүгээс зохион байгуулсан байна.

Merси Корп ОУБ-аас хэрэгжүүлж байгаа арга хэмжээ

АНУ-ын ХАА-н Департаментээс санхүүжсэн ХАБДХ (Хөдөөгийн Агрибизнесийг Дэмжих Хөтөлбөр)-ийн хүрээнд 2012 онд 5 томоохон ажлыг хийж гүйцэтгэсэн. (Хүснэгт)Мөн энэ онд “Бэлчээрийн хорт болон голлох эмийн ургамал”, “Малын нутагшмал эмгэг өнгөт атлас” номуудыг шинээр боловсруулж, “Эндемик өвчин” номыг зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэйгээр, “Мал эмнэлгийн холбогдолтой журам зааврууд” эмхэтгэлийг дахин 2000 хувиар хэвлэсэн байна. Тус төслийн зүгээс 2012 онд 149.96 сая төгрөгний 5 ажил хийгдсэн бөгөөд энэ нь малын эмч нарын мэдлэг чадвар дээшлэн, мал эмнэлгийн үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх, хүнсний аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн үр дүнтэй хөрөнгө оруулалт болсон.

1.6.4. Орсолдөөн, орсолдөгчид


Улсын хэмжээнд 2013 оны жилийн эцсийн байдлаар мал эмнэлгийн төв байгууллага, лаборатори, аймгийн эмнэлгийн алба, лабораторит 432, төрийн мал эмнэлэг, үржлийн нэгжид 329 сум, дүүргийн түвшинд 879 хувийн мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжид их эмч 643, бага эмч 783, мал зүйч 153 нийт 2,458 хүн ажиллаж, нэг нэгжид 49.6 мянга, нэг малын эмчид 30.5 мянган мал ноогдож 2013 онд хийгдсэн стандартын түвшин тогтоох үзлэгээр нийт нэгжийн 88.0% нь ажлын байр, 93.0% нь шаардлага хангасан унаатай, 9.0% нь стандартын шаардлага бүрэн хангасан, 55.0% нь стандартын шаардлага хангаж байгаа, 36.0% нь дундаас доош түвшинд байгаа дүн үзүүлээд байна.

Стандартын үзлэгийн дүнг үндэслэн зөвлөмж гарч аймаг, нийслэлийн ҮХААГазар, МГААлба, МУАлбанд хүргэгдэн улсын хэмжээнд ажиллаж буй хувийн хэвшлийн МЭҮНэгж бүрт ололттой талыг дэмжин дэлгэрүүлэх, дутагдлыг засч стандартын шаардлагыг биелүүлж ажиллах зөвлөмжийг боловсруулан хүргэж, эргэж мэдээлэн хамтран ажиллахаар бэлдэж байна. Энэ зөвлөмжийг хэрэгжүүлэн 2014 онд нийт хувийн хэвшлийн МЭҮНэгжийн 50-аас доошгүй хувь нь стандартын шаардлагыг бүрэн хангасан нэгж болж ажиллах зорилт дэвшүүлээд байна.


График 6. Нэг эмчид ногдох малын тоо



График 7. Малын эмч нарын ажлын байрны судалгаа



Малын эмийн чиглэлээр мал эмнэлгийн зориулалттай эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй 8 компани, мал эмнэлгийн зориулалттай эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрөлтэй 79 компани, Улаанбаатар хотод 20 малын эмийн сан, аймгуудад Малын эмийн ханган нийлүүлэх сүлжээний 22 аж ахуйн нэгж, хөдөө орон нутагт хувийн мал эмнэлэг үйлчилгээний 800 гаруй нэгжийн эмийн сангаар дамжуулан мал бүхий иргэдийг улсын бүртгэлд бүртгэгдсэн 520 нэр төрлийн чанарын баталгаатай, ондөр илгэвхигэй эмээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.



Мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөлтэй 87 аж ахуйн нэгжүүд 30 орны 80 аж ахуйн нэгжүүдээ паразиттах өвчний болон өргөн хэрэглээ, ариутгалын 2.0 тэрбум гаруй төгрөгний эм бэлдмэлийг импортлосон байна.

Аймгуудад үйл ажиллагаа эрхэлж буй эм ханган нийлүүлэх сүлжээ аж ахуйн нэгжүүд мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн захиалгат эмийн 60- 80%-ийг ханган ажиллаж байна. Малын эмийн улсын бүртгэлд бүртгүүлэхээр ирүүлсэн материалыг хэлэлцүүлэн 8 аж ахуйн нэгжийн 50 эм бэлдмэл бүртгэгдэн зааврыг хэвлүүлэхээр Олон улсын төсвийн бангуудлагатай хамтран ажиллаж байна.

Малын эмийн үйлдвэрлэл эрхэлж байгаа:

- Горийн өмчийн болон хувийн хэвшлийн эмийн үйлдвэр 8

- Малын эм импортлох үйл ажиллагаа эрхэлж байгаа 67 аж ахуйн нэгж, байгууллага нь улсын малын эмийн бүртгэлд 26 орны 471 нэр төрлийн эм бүртгүүлжээ.

1.6.5 SWOT шинжилгээ

Хүснэгт 3. SWOT шинжилгээ

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
<ol style="list-style-type: none"> 1. Тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа; 2. Үйл ажиллагааны зардал бага /Цалин гэх мэт/; 3. Бараа бүтээгдэхүүн борлуулах сувгаа зөв тодорхойлж чадсан; 4. Байнгын үйлчлүүлэгч, хэрэглэгч, өөрийн борлуулалч нартай болсон; 	<ol style="list-style-type: none"> 1. Үйл ажиллагаа явуулах өөрийн байргүй; 2. Компанийн засаглалыг компанид нэвтрүүлээгүй;
БОЛОМЖ	АЮУЛ
<ol style="list-style-type: none"> 1. Нээлттэй хувьцаат компани болж үйл ажиллагаагаа өргөжүүлэх; 2. Үйл ажиллагааны чиглэлийг тодорхойж ил чиглэлдээ тэргүүлэгч компани болох; 3. Онлайн сүлжээтэй, худалдааг бий болгох 	<ol style="list-style-type: none"> 1. Байгаль цаг уурын эрсдэл борлуулатын үйл ажиллагаанд сөрөг нөлөө шууд үзүүлдэг. 2. Өрсөлдөгч ихтэй 3. Ханшийн өөрчлөлтийн эрсдэл 4. Хүний нөөцийн эрсдэл

1.7 Борлуулалт, маркетингийн төлөвлөгөө

Малын эмнэлэг, эрүүл мэндийн салбарт нийтдээ 827 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг бүртгэлтэй байдаг бөгөөд БИНСЭ ХК-ийн хувьд 2014 оны эхний байдлаар мал эмнэлгийн чиглэлээр аймаг, сумдал мал эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлдэг нийт 257 аж ахуйн нэгжтэй гэрээгээр хамтран ажиллаж байна. Үүнээс:

График 8. БИНСЭ ХК-ийн гэрээт борлуулагчдын тоо, аймгаар



Гэрээт борлуулагчдаа байршуулсан 19 аймгаас Хөвсгөл, Архангай, Завхан аймгууд нь хамгийн олон харилцагчтай, борлуулалт тогтмол сайн байдаг идэвхитэй бүс нутаг юм. Одоогоор Төв болон Сэлэнгэ аймгуудад гэрээт борлуулалт байхгүй байгаа бөгөөд Төв аймаг нь газарзүйн байршлын хувьд Улаанбаатар хоттой ойр тул, тус аймгийн малчдад Улаанбаатар хотын борлуулагчдаар дамжуулан бүтээгдэхүүнээ нийлүүлдэг. Харин Сэлэнгэ аймагт ойрын хугацаанд гэрээт борлуулагчтай болох зорилттой ажиллаж байна.





График 9. БИНСЭ ХК-ийн борлуулалтын сүвгийн бүлүүвч зураг



1.7 Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5-аас дээш хувийг эзэмшдэг этгээдийн талаарх мэдээлэл


Хүснэгт 4. Нийт хувьцааны 5%-с дээш хувь эзэмшигчдийн мэдээлэл

№	Нэр	Иргэн бол эрхэлдэг ажил, хуулийн этгээд бол байршил	Эзэмшиж буй хувьцаа
1	Л.Онөрхуяг	“Alliance gold” ХХК, Ерөнхий захирал	10.0%
2	Б. Батзаяа	БИНСЭ ХК-ийн захирал	24.0%
3	Б.Чинчулуун	МЭХүрээлэн, ЭША	10.0%
4	Б.Отгонбаяр	БИНСЭ ХК борлуулалтын хэлтэс дарга	7.0%
5	М. Идэртөр	Малын эмч нарын залуу үе ТББ захирал	10.0%
6	Ц. Өлзийбаяр	Тэнүүн өрлөг ХХК захирал	8.0%
7	Г.Жамсрандорж	“Нэйшнл Инвестмент Менежмент” ХХК	10.0%

1.8 Эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл тэдгээр тухайн компанийн хувьцааг эзэмшдэг бол түүний хувь хэмжээ

Хүснэгт 5. Эрх бүхий албан тушаалтны мэдээлэл

№	Нэр	Иргэн бол эрхэлдэг ажил, хуулийн этгээд бол байршил	Эзэмшиж буй хувьцаа
1	Б.Батзаяа	Гүйцэтгэх захирал	24.0 %
2	А.Эрдэнэчимэг	Нягтлан бодогч	0.07 %
3	Т.Цогтбаяр	ТУЗ-ийн Дарга	0%
4	Т.Ганжигүүр	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	0 %
5	Б.Отгонбаяр	ТУЗ-ийн хараат гишүүн	7.0 %
6	Ч.Оюунцэцэг	ТУЗ-ийн хараат гишүүн	3.63 %
7	М.Адилбиш	ТУЗ-ийн хараат гишүүн	0 %
8	Ц.Өлзийбаяр	ТУЗ-ийн хараат гишүүн	8.0 %
9	С.Ганбат	ТУЗ-ийн хараат гишүүн	3.63%
10	Ж.Өлзийбаяр	ТУЗ-ийн хараат бус гишүүн	3.47 %
11	Ц.Онөржаргал	ТУЗ-ийн хараат бус гишүүн	0 %
12	Ц.Алтансүх	ТУЗ-ийн хараат бус гишүүн	0 %



1.9 Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлд бүртгэгдсэн дүрэмд тусгагдсан ногдол ашгийн бодлогын талаарх мэдээлэл

2014 оны 4-р сарын 16-нд хуралдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн дүрмийг өөрчлөн баталсан. Компанийн дүрэмд ногдол ашгийн талаар дараах заалтуудыг оруулсан:

Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. ТУЗ шийдвэртээ хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлтэй хамт мэдээлэл хүргүүлнэ.

Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлд цэвэр ашигаас ногдол ашиг хуваарилна:

- Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
- Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, энэ дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;
- Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх;

Ногдол ашиг хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25 - аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үүргийг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

Ногдол ашиг хуваарилаагүй бол ТУЗ шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээний санг ТУЗ - ийн шийдвэрээр байгуулж болох бөгөөд уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг гүйцэтгэх захирал боловсруулж ТУЗ - ийн хурлаар батлуулж мөрдөнө.

Ногдол ашгийг ТУЗ - өөс тогтоосон хугацаанд төлөөгүй бол хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх бөгөөд үүнээс компанид учирсан хохирлыг гүйцэтгэх захирал хариуцна.

Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ - ийн шийдвэр гарсан үед төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтлөнө. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигч бүрийн арилжааны банкин дах дансанд шилжүүлэх бодлого баримтална.

Ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын санхүүгийн тайлан гаргах үед ногдол ашгийн хуваарилалтын тайланг гаргаж Санхүүгийн Зохицуулах Хороо, Хөрөнгийн

биржил хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.

1.10 Сүүлийн 3 жилийн болон үнэт цаасыг бүртгүүлэхээр зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргахын өмнөхулирлын аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн үндсэн үзүүлэлтүүд

БИНСЭ ХК-ийн сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан, тэнцэлд “Сүлд-Аудит” Аудитын компани дүгнэлт гаргасан байгааг нэгтгэн харуулав. Жилийн эцсийн тайлан, аудитын тайланг хавсралтаар оруулав.

Хүснэгт 6. БИНСЭ ХХК-н санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД (млн.төгрөгөөр)	2012	2013	2014-III
СҮЛД ӨГДӨЛ ТЭНЦЭЛ			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,893.07	2,395.81	2,486.50
Дансны авлага	856	19,312.00	49,065.60
Бусад авлага	-	88,000.00	88,022.80
Бараа материал	88,139.31	141,712.46	161,489.80
Урьдчилж төлсөн зардал	900		81,489.40
ӨРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	91,788.38	251,420.27	382,554.00
Үндсэн хөрөнгө	13,146.02	22,731.51	25,336.50
Биет бус хөрөнгө	370	370	
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	101,421.85	211,141.80
ӨРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	13,516.02	124,523.36	236,478.30
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	105,304.39	375,943.63	619,032.30
Дансны өглөг	29,274.57	7,325.50	182,684.80
Татварын өр	25,654.02	26,671.63	178,936.50
НДШ-ийн өглөг	-	506	1702.6
Богино хугацаат зээл	-	138,166.92	121,431.90
Урьдчилж орсон орлого	8,666.40	8,666.40	-
БӨЛӨНЦӨ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	63,594.98	181,336.45	323,712.80
Урт хугацаат зээл	15,500.00	-	125,000.00

УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	15,500.00	-	125,000.00
ОР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	79,094.98	181,336.45	448,712.80
Эзэмшигчийн өмч	1,000.00	89,000.00	126,832.00
Нэмж төлөгдсөн капитал	-	25,008.82	0
Хуримтлагдсан ашиг	25,155.41	80,598.37	43,487.50
ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН	26,155.41	194,607.18	170,319.50
ОР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	105,250.39	375,943.63	619,032.30

II. ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН


Борлуулалтын цэвэр орлого	454,440.25	401,791.39	2,076.40
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	285,662.60	192,129.33	2,076.40
НИЙТ АШИГ	168,777.65	209,662.06	0
Үйл ажиллагааны зардал	134,099.41	147,552.90	31,617.00
Үйл ажиллагааны бус ашиг (алдагдал)	-4,726.00	1.64	0
ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ	29,952.23	62,110.79	-31,617.00
Орлогын татварын зардал	3,337.32	6,684.54	0
ЦЭВЭР АШИГ /АЛДАГДАЛ/	26,614.91	55,426.25	-31,617.00

III. ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Эхний үлдэгдэл	1,000.00	26,155.41	21,570.60
Нэмэгдсэн	25,155.41	168,451.78	148,748.90
Хорөгдсөн	-	-	-
Эцсийн үлдэгдэл	26,155.41	194,607.18	170,319.50

IV. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	8,839.12	47,678.65	54,341.70
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	-2,913.25	-81,854.71	306,050.00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-4,500.00	34,732.81	115,150.40
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,425.87	556.75	2,959.70



1.11 Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан их хэмжээний хэлцэл, хараат бус хууль зүйн дүгнэлт

Хувьцаа эзэмшигчидийн ээлжит бус хурлын 2014 оны 10 сарын 27-ны өдрийн 1/14 тоот шийдвэрээр олгосон эрхийн дагуу Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2014 оны 10 сарын 27-ны өдрийн 8/14 тоот тогтоолоор 300.000 /гурван зуун мянга/ ширхэг хувьцааг хаалттай хүрээнд санал болгох, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 01 сарын 28-ны өдрийн 70 тоот тогтоолоор 200.000 /хоёр зуун мянга/ ширхэг хувьцааг нэг бүрийг нь 1000 /нэг мянга төгрөгөөр өрийг хувьцаагаар солих хэлбэрээр мөн 500.000 /таван зуун мянга/

ширхэг хувьцааг олон нийтэд гаргаж арилжаалах эрхийг ТУЗ-ийн хуралд олгосон бөгөөд нийт 1,000,000 /сая/ ширхэг хувьцааг нэмж гаргахаар шийдвэрлэсэн.

1.12 Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэсэн тухай мэдээлэл, бизнесийн үнэлгээний талаарх үнэлгээний байгууллагын дүгнэлт

Хөрөнгийн үнэлгээний “Эвиденсе аудит” ХХК нь нэгдэж буй БИНСЭ ХХК-н хараат бус хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг хийсэн. Уг тайланг хавсралтаар оруулав. БИНСЭ ХХК-ийн хөрөнгийн үнэлгээг хийхдээ 100 хувийн оролцооны цэвэр хөрөнгийн өртгийн хандлагаар тооцоолсон бөгөөд өнөөгийн зах зээлийн үнэ цэнэ **240,163,856** буюу *(Хоёр зуун дөчин сая нэг зуун эсрэн гурван мянга найман зуун тавин зургаа)* төгрөг хэмээн үнэлжээ.

Тус компани бизнесийн үнэлгээг хийхдээ зах зээлийн жишиг үнийн хандлага, орлого капиталжуулалтын хандлага, цэвэр хөрөнгөнд суурилсан үнийн хандлага болох 3 аргыг ашигласан. Уг арга тус бүрээр, компанийн үнэ цэнэ дараах байдалтай байна.

Хүснэгт 7. Бизнесийн үнэлгээ

№	Бизнесийн үнэлгээний арга зам	Тухайлсан үнэ цэнэ /төгрөг/
1	Зах зээлийн жишиг үнийн хандлага	149,893,580
2	Орлого капиталжуулалтын хандлага	516,307,000
3	Цэвэр хөрөнгөнд суурилсан үнийн хандлага	240,163,856
	Компанийн үнэ цэнэ	516,307,000

“Эвиденсе аудит” ХХК нь захиалагчийн хийлгэж байгаа үнэлгээний зориулалтыг харгалзан БИНСЭ ХХК-ийн бизнесийн үнэлгээг хийхдээ цаашид тус компанийн тааралгүй үйл ажиллагаа явуулах, бизнесийн цар хүрээ зэргийг харгалзан, “Орлого капиталжуулалтын хандлага”-ын үнэлгээгээр нэгдсэн үнэлгээг дээрх байдалтай буюу **516,307,000 /Таван зуун арван зургаан сая, гурван зуун долоон мянга/** төгрөг гэж үнэлсэн байна.

1.13 Төлөрхөй төсөл хэрэгжүүлэхээр үнэт цаас гаргаж байгаа бол түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл (тусгай зөвшөөрөл, газар эзэмших эрх, лицензи, патент зэрэг шаардлагатай бусад эрхүүд)-ийн талаарх мэдээлэл

БИНСЭ ХК-ийн хувьд:

→ Тусгай зөвшөөрөл: Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл

2014/093 дугаар бүхий малын эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрөл (2014.11.01-2017.11.01), Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн

үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2011 оны 11 сарын 17-ны өдрийн А/407 тоот тушаалыг үндэслэн олгосон байна.

II. ТАНИЛЦУУЛГЫН ХОЁРДАХЬ ХЭСЭГ

2.1 Үнэт цаасны төрөл, хэлбэр: Энгийн хувьцаа

2.2 Үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах тухай үнэт цаас гаргагчийн эрх бүхий байгууллагын шийдвэр. Хэрэв уг үнэт цаасыг гаргах нь тухайн компанийн хувьд их хэмжээний хэлцэлд тооцогдохоор бол шийдвэрийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу гаргасан тухай мэдээлэл

Компани нэмж гаргах үнэт цаасаа компанийн зарласан хувьцаанаас нэг бүр нь 100 /зуу/ тогрогийн нэрлэсэн үнэтэй 1,000,000 /нэг сая/ ширхэг хувьцааг нэмж гаргаж байгаа болно. Холбогдох ХЭЭБХ-ын шийдвэр, ТУЗ-ийн тогтоолыг хавсралтаар оруулав.


2.3 Үнэт цаасыг арилжаалах арга хэлбэр, график, санал болгох хүрээ

"БИНСЭ" ХК нь хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний дагуу ~~мон эргэлтийн~~ хөрөнгөө сайжруулахаар нэмж хувьцаа гаргаж байгаа ба 1,000,000 /нэг сая/ ширхэг хувьцааг хаалттай хүрээнд арилжаалах болно.

- 200,000 /хоёр зуун мянга/ ширхэг энгийн хувьцааг нэг бүрийг нь 1000 /нэг мянга/ тогроогоор Б.Батзаяал хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний дагуу хаалттай хүрээнд эзэмшүүлэх
- 300,000 /гурван зуун мянга/ ширхэг хувьцааг хаалттай хүрээнд арилжаалах
- 500,000 /таван зуун мянга/ нээлттэй зах зээлд арилжаалах

Хувьцаа эзэмшигчидийн ээлжит бус хурлын 2014 оны 10 сарын 27-ны өдрийн 01/14 тоот тогтоолоор нэмж хувьцаа гаргах, тус өдрийн 02/14 тоот тогтоолоор өрийг хувьцаагаар олгох тухай төслийг баталсан болно.

2.4 Урьд нь үнэт цаас гаргаж байсан эсэх, гаргаж байсан бол үнэт цаасны нэр төрөл, гаргасан огноо, нийт хэмжээ, төлөгдөх буюу төлөгдсөн хэмжээ, өрийн бичиг гаргасан бол үндсэн болон хүүгийн төлбөрийг хугацаанд нь барагдуулж байсан тухай үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагын тодорхойлолт байгаа тухай мэдээлэл



"БИНСЭ" ХК нь 2014 онд МХБ дээр бүртгэгдсэн бөгөөд нийт 1,268,320 /нэг сая хоёр зуун жаран найман мянга гурван зуун хорин төгрөг/ ширхэг энгийн хувьцаатай болно. Өрийн бичиг гаргаж байгаагүй. "Монголын Хөрөнгийн бирж" ХК болон "ҮЦТТХТ" ХХК –с тус компаниатай холбоотой ямар нэгэн тооцоо байхгүйг баталсан албан тодорхойлолтыг хавсралтаар оруулав.

2.5 Үнэт цаас гаргах замаар хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах төслийн товч танилцуулга, эдийн засгийн үр ашгийн тооцоо

- Компани нь нэмж хувьцаа гаргаснаар өөрийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилготой байгаа бөгөөд хувьцаа эзэмшигчдийнхээ хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах, ашиг орлоготой ажиллах зорилтын хүрээнд монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй шилдэг компанийн нэг болж, компанийн хувьцааны хөрвөх чадвар сайжирсанаар хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг дээд зэргээр хангагдана.
- Бизнесийн үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх;
- Ирээдүйд тогтвортой урт хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэртэй болох;
- Борлуулагчдыг хөрөнгө оруулагчаар татаж үйл ажиллагаанд оролцуулж стратегийн түнш болгох боломж бүрдэх;



Эдгээр шалтгааны улмаас "БИНСЭ" ХК нь нэмж хувьцаа гаргах нь зүйтэй гэж хувьцаа эзэмшигчид болон ТУЗ үзсэн болно.

Нэмж хувьцаа гаргах замаар 300 сая /гурван зуу/ төгрөгийг төвлөрүүлэх бөгөөд уг мөнгөөр эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлж, бараа бүтээгдэхүүн татан авахаар төлөвлөөд байна. Бараа татан авалтын дэлгэрэнгүй тооцоог дараах хүснэгтээс:


Хүснэгт 8. Бараа татан авалт

№	Бүтээгдэхүүний нэр төрөл	FOB үнэ /ам доллар/	Тоо ширхэг	FOB үнэ	Валютын ханш	Нийт өртөг /Төгрөг/
				I улирал		
1	Anti parasite					
1	Гормес 1 %	1.17	50,000	58,500	1,900	111,150,000
2	Горалбен 10%	4	20,000	80,000	1,900	152,000,000
	Нийт дүн					263,150,000
				II улирал		
1	Гормес 1 %	1.17	30,000	35,100	2,000	70,200,000
2	Горалбен 10%	4	20,000	80,000	2,000	160,000,000
	Нийт дүн					230,200,000

2015 онд нэмж татсан 300 сая төгрөгийг бараа татан авалтанд оруулж тооцсон бөгөөд 2015 онд нийт 2 тэрбум төгрөгийн борлуулалт хийхээр төлөвлөж төсөөлсөн орлогын тайланг бэлтгэвээ.

Хүснэгт 9. Орлогын тайлангийн төсөөлөл сая төгрөгөөр/

	2013	2014	2015	2016	2017
Инфляцийн түвшин /өөрчлөлт/	13.0%	12.3%	10.0%	10.0%	10.0%
Өөрчлөлт		-0.70%	-2.30%	0.00%	0.00%
Валютын ханш	1,450	1,850	1,900	1,900	2,000
Борлуулалтын орлого	401.8	800.0	2,087.3	2,462.6	2,523.1
Утасны борлуулалтын орлого	401.8	800.0	2,087.3	2,462.6	2,523.1
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	192.1	400.0	1,176.3	1,546.9	1,432.9
Нийт ашиг	209.7	400.0	911.0	915.7	1,090.3
Үйл ажиллагааны зардлууд	117.6	212.4	386.3	485.2	511.2
Цалингийн зардал	21.6	52.8	94.8	141.6	147.0
Нийгмийн даатгалын зардал	2.6	6.3	11.4	17.0	17.6
Түрээсийн зардал	18.9	21.9	25.4	29.5	34.2
Албан томилолтын зардал	5.3	6.0	6.7	7.6	8.6
Тээврийн зардал	6.8	40.0	104.4	123.1	126.2
Элдгийн зардал	2.9	2.9	2.9	2.9	2.9
Зар сурталчилгааны зардал	2.4	2.8	3.4	4.1	4.9
Шагнал урамшууллын зардал	15.0	32.0	83.5	98.5	100.9
Бичиг хэргийн зардал	1.9	2.1	2.4	2.7	3.0
Шуудан холбооны зардал	4.3	4.9	5.5	6.2	7.0
Хяналтын зардал	0.6	0.7	0.8	0.9	1.0
Шатахууны зарал	1.6	1.9	2.1	2.4	2.8
Бусад зардал	33.7	38.1	43.0	48.6	55.0
Хүү, татварын өмнөх ашиг	92.1	187.6	524.6	430.5	579.1
Хүүгийн зардал	30.0	21.6	9.3	5.6	2.9
Орлогын татварын зардал	6.7	16.6	51.5	42.5	57.6
Татварын дараах нэвэр ашиг	55.4	149.4	498.7	408.3	559.6



Хүснэгт 10. Мөнгөн урсгалын тайлангийн төсөөлөл сая төгрөгөөр/

	2013	2014	2015	2016	2017
Орох мөнгөн урсгал					
Борлуулалтын орлого					
Үндсэн борлуулалтын орлого	401.79	800.00	2,087.27	2,462.60	2,523.13
Гэрээт борлуулалтын орлого			-	-	-
Олон нийгэд хувьцаа нэмж гаргах			-	600.00	
Нийт орох мөнгөн урсгал	401.79	800.00	2,087.27	3,062.60	2,523.13
Гарах мөнгөн урсгал					
Бараа материалын төлбөрт	236.67	590.10	1,176.30	1,546.88	1,432.87
Үйл ажиллагааны зардал:					
Цалингийн зардал	21.61	52.80	94.80	141.60	147.00
Нийгмийн даатгалын зардал	2.59	6.34	11.38	16.99	17.64
Түрээсийн зардал	18.88	21.90	25.41	29.47	34.19
Албан томилолтын зардал	5.28	5.97	6.75	7.62	8.61
Тээврийн зардал	6.83	40.00	104.36	123.13	126.16
Элдвийн зардал	2.91	2.91	2.91	2.91	2.91
Зар сурталчилгааны зардал	2.37	2.84	3.41	4.09	4.91
Шагнал урамшууллын зардал	15.00	32.00	83.49	98.50	100.93
Бичиг хэргийн зардал	1.86	2.11	2.38	2.69	3.04
Шуудан холбооны зардал	4.30	4.86	5.50	6.21	7.02
Ашиглалтын зардал	0.59	0.68	0.79	0.90	1.04
Шатахууны зарал	1.64	1.86	2.13	2.42	2.76
Бусад зардал	33.71	38.09	43.04	48.63	54.96
Үйл ажиллагааны бус зардал					
Нэгдүгэй компани болох төсөл хэрэгжүүлэх					
Нэмж хувьцаа гаргах төсөл		30.00	30.00		
Эм ханган нийлүүлэх төв байгуулах төсөл					
Сулалгаа			10.00		
Барилгын ажил				500.00	
Онлайн сүлжээ			50.00		
Гатварын зардал	16.60				
Бусад зардал	29.98	21.64	9.30	5.64	2.90
Зөдийн эргэн төлөлт					

БИНСЭ ХК-ийн нэмж гаргах үнэт цаасны танилцуулга

	62.00	88.00	32.00	56.00
ХНХ зохион байгуулах	-	1.00	1.00	1.50
Ногдол ашиг хуваарилах	-	-	-	-
Нийт гарах мөнгөн урсгал	400.82	916.11	1,750.92	2,570.70
Швэр мөнгөн урсгал	0.97	116.11	336.35	491.90

Дээрх тооцооноос харвал 2014 онд 149.4 сая төгрөг, 2015 онд 498.7 сая төгрөгийн ашигттай ажиллахаар харагдаж байна. Түүнчлэн 2015 онд эм ханган нийлүүлэх төв барих ажлыг эхлүүлэх бөгөөд судалгааны ажилд 10 сая, бараа бүтээгдэхүүн борлуулах онлайн сүлжээг өнн бодлох ажилд 50 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөөд байна. Мөн 2015 оны сүүлээр нэмж хувьцаа гарган хөрөнгө төвлөрүүлж, 2016 онд уг төвийн барилгын ажлыг хийхээр төлөвлөөд байна.

Борлуулалтын орлого болон татварын дараах цэвэр ашгийг харьцуулсан график байгуулав.

График 10. Тайлангийн шинжилгээ



Хүснэгт 10-г оруулалтаар зориулсан энгийн шинжилгээг хийж харуулав.


Хүснэгт 11. Тайлангийн шинжилгээ

Үзүүлэлт	2014	2015	2016	2017
Татварын дараах цэвэр ашиг	149,392,821.14	498,749,086.65	408,300,472.68	559,596,429.15
Хувьцааны ширхэг	1,768,320.00	2,268,320.00	2,268,320.00	2,268,320.00
Үнэ	600.00	650.00	700.00	750.00
Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS)	84.48	219.88	180.00	246.70
Үнэ ашгийн харьцаа (P/E)	7.10	2.96	3.89	3.04
Төлөвшилдүйн	118%	393%	322%	441%

Өмчийн өгөөж (ROE)				
Хөрөнгийн өгөөж (ROA)	24%	81%	66%	90%

Энгийн хувьцаанд хөрөнгө оруулагчид нь оруулсан хөрөнгөөсөө ногдол ашиг авах хэлбэрээр эсвэл хувьцааны үнийн өсөлтөөс өгөөж хүртдэг. Нэгж хувьцаанд ногдох ашиг нь 2015 онд 219.88 төгрөг байснаа 2016 онд 180 төгрөг болж буурч байгаа нь 2016 онд эм ханган нийлүүдэх төв барихтай холбоотой. Үнэ ашгийн харьцаа нь тухайн компанийн хувьцааны эрэлтийг харуулдаг гол үзүүлэлт бөгөөд хувьцааны нэгжид ногдох нэг төгрөг ийн ашигт хөрөнгө оруулагчид хэдэн төгрөг толж байгааг харуулдаг. Уг дүн нь 2014 онд 7.10, 2015 онд 2.96, 2016 онд 3.89, 2017 онд 3.04 болж буурч байгаа нь жил ирэх бүр компанийн ашигт ажиллагаа нэмэгдэж, нэгж хувьцаанд ногдох боломжит ашгийн түвшин хурдангай өсч байгаатай холбоотой. Зах зээлд идэвхитэй арилжаалагддаг компаниудын хувьд тухайн үзүүлэлт нь 15-с бага байхад хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц үзүүлэлт болдог тул дээрх тооцоолсон үнэ ашгийн харьцаа нь хөрөнгө оруулагчдын хувьд таатай үзүүлэлттэй байна.

Хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийн үр ашгийг тооцоолдог гол үзүүлэлтүүд болох эзэмшигчийн өмчийн өгөөж, хөрөнгийн өгөөж нь маш эерэг үзүүлэлттэй байгаа нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц байна.



2.6 Тухайн үнэт цаасыг худалдан авснаар хөрөнгө оруулагчид учирч болох эрсдэл, эрсдлийн шинжилгээ

"ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 7.1-Д ЗААСНЫ ДАГУУ НИЙТГЭД ЭРСДЭЛ БӨЛГӨН ХУДАЛДАХААР ГАРГАЖ БУЙ ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД **ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ** ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА".

“БИНСЭ” ХК-ийн энгийн хувьцааг хаалттай хэлбэрээр худалдаалахад хөрөнгө оруулагчид компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй дараах төрлийн эрсдэлүүд үүсэх магадлалтай.

Салбарын эрсдэл

Мал аж ахуйн салбар нь улсын хэмжээнд тэргүүлэх салбар төдийгүй цаашид малын тоо толгой өсөн нэмэгдэхийн хэрээр мал эмнэлэг, малын эм бэлдмэл үйлдвэрлэлийн салбарын хүрээнд өргөж, зах зээл нь өргөжих боломжтой. Салбарын хувьд нэгдсэн системгүй, малын эм тарианы хяналт сул малын эм, био бэлдмэлийн үйлдвэрийн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд МХЕГ-аас хийсэн шалгалтаар ихээхэн зөрчил илэрдэг. Тухайлбал 2014 оны эхээр хийсэн малын эм бэлтгэдэг үйлдвэрийн үйл ажиллагааны шалгалтаар 60 хувь нь өндөр эрсдэлтэй, 40 хувь нь бага эрсдэлтэй гэсэн үнэлгээ авсан. БИНСЭ ХК-ийн хувьд Канад улсын “Topsurf” брэндийн стандартын шаардлагад нийцсэн, Монгол улсын эмийн бүртгэлд бүртгүүлсэн эм бэлдмэл, багаж хэрэгслийг эх орондоо импортолж, орон нутгийн малын эмч, болоод мал эмнэлгүүдэд нийлүүлдэг тул энэ төрлийн эрсдлээс ангид байна.

Төрийн оролцоо

Төрийн оролцоо гэдэг утгаараа зах зээлийн бус аргаар өрсөлдөх хэлбэр олон тохиолддог. Ерөнхийдөө улс төрийн болон хөрөнгө ихтэй компанийн нөлөө харьцангуй бага боловч, сонирхлын зөрчилтэй, хувийн бизнесийнхний оролцоо ихтэй. Тухайлбал, малын эрүүл мэндийг дэмжих төрийн бодлогын хүрээнд засгийн газрын худалдан авах үйл ажиллагаа нь дүрэм, журмын дагуу явагддаггүй, сонирхлын зөрчил их хэмжээгээр үүсдэг зэргээр өрсөлдөөнд саал учруулдаг.


Голорхой хязгаарлагдмал хүрээний буюу цөөн тооны бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчийн эрсдэл

Компанийн хувьд Канадын Topsurf компанийн БНХАУ-улын Нанжин хот дахь үйлдвэрээс бүтээгдэхүүн импортолж, борлуулдаг. Ганцхан тооны бэлтгэн нийлүүлэгчтэй байгаа нь бүтээгдэхүүн татан авалт хоцрох, хойшлох, тухайн үйлдвэрт аливаа гамшиг, осол гарсан тохиолдолд эрсдэлд орох магадлалтай. Компани энэ эрсдлээс зайлсхийхийн тулд бүтээгдэхүүний нэр төрлөө нэмэгдүүлэх, олон газраас татан авалт хийдэг байх стратеги барьж, хэд хэдэн бэлтгэн нийлүүлэгчтэй болохыг эрмэлзэн ажиллаж байна. Одоогоор хэд хэдэн нийлүүлэгчийн сонгон, судалж байгаа ба БНЭУ-ын 1 үйлдвэр, Турк улсын 1 үйлдвэр, Араб улсын 1 үйлдвэр, БНХАУ-ын 1 үйлдвэртэй хамтрах ажил гэрээний шатандаа явж байна.

Зах зээлийн эрсдэл /өрсөлдөгч компанийн чадвар, татварын дарамтын эрсдэл, бараа бүтээгдэхүүний үнэ өсөх, инфляци/

Монгол улс нь эрт дээр үеэс мал аж ахуйн орон байсаар ирсэн бөгөөд өнөөг хүртэл нийт хүн амын тодорхой хэсэг бэлчээрийн мал аж ахуйг эрхэлсээр байна. Энэ хугацаанд малын үүдтэр хугааг сайжруулах талаар малчид өөрсдийн уламжлалт аргаар ажиллаж ирсэн бөгөөд товлорсон төлөвлөгөөг зах зээлийн үед нэгдсэн бодлогын хэрэгжүүлж байсан боловч зах зээлийн нийгэмд шилжснээр нэгдлийн гэх тодотголтой мал аж ахуйн сууриудыг тарааж иргэдэд хувьчилсан. Энэ үеэс эхлэн мал эмнэлэгүүдийн үйл ажиллагаа алдагдаж, малын эрүүл байдал алдагдаж эхэлсэн. Мөн түүнчлэн хувийн мал эмнэлэгийн тоо олширч өрсөлдөөнийг бий болгосон төдийгүй эм, эмнэлгийн багаж хэрэгсэл импортлогч компаниудын тоо нэмэгдсэн. Энэ нь “БИНСЭ” ХК-ийн хувьд тухайн зах зээлд өөрийн байр суурийг олж авахад өрсөлдөгчид сөрөг нөлөө үзүүлэх бөгөөд компанийн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэхэд бэрхшээл учруулах эрсдэлтэй. Тиймээс БИНСЭ ХК нь гэрээт борлуулагчидлаа өөрийн компанийн хувьцаанаас эзэмшүүлснээр, тогтвортой борлуулагчидтай болж, одоогийн зах зээлд байр сууриа хадгалж үлдэх, түүнчлэн нэмэгдүүлэх бодлого барьж байна.

Хэдийгээр манай улс бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэхийг хичээж байгаа боловч гадаад, дотоодын байгууллагууд манай орны төрийн бодлого болон хууль эрх зүйн орчинг тогтворгүй гэж дүгнэдэг. Өөрөөр хэлбэл Нэмэгдсэн орчин албан татвар, Гаалийн татвар, Онцгой албан татвар зэрэг нь компанийн санхүүгийн байдалд дарамт болох эрсдэл бий.



Аливаа худалдааны байгууллагын хувьд гаднаас авах бараа бүтээгдэхүүний үнэ өсөх, эсвэл борлуулахаар худалдан авсан бараа бүтээгдэхүүний үнэ буурах нь томоохон эрсдэл болдог. Үүнийг хязгаарлахын тулд харилцагч байгууллага болон гэрээт борлуулагч нартайгаа урт хугацааны гэрээ байгуулж эрсдлийг бууруулах боломжтой.

Үйл ажиллагааны эрсдэл /менежерийн ур чадвар, хүний нөөц, мөнгөн гүйлгээ хүний нөөцийн эрсдэл

“БИНСЭ” ХК нь малын эм, бэлдмэл, мал эмнэлэгийн багаж хэрэгсэлийн худалдаа эрхэлж эхэлснээс хойш энэ салбартаа арвин их туршлагатай болсон. Хүний нөөцийн тухайд одоо үйл ажиллагаа эрхэлж мэргэжилтэнүүд нь компанийн үйл ажиллагааны чиглэл зорилгын талаар тодорхой мэдэж байгаа боловч ур чадвар, дадлага туршлагатай ажиллах хүчний өрсөл үүсэх магадлалтай. Энэхүү эрсдэлийг давах туулахын тулд ажилчдын ажлыг дүгнэх нэгдсэн тогтолцоо бүрдүүлэхийн тулдажлын төлөвлөлт гүйцэтгэлийн программыг нэвтрүүлэн ажиллаж байна.

“БИНСЭ” ХК-ийн хэрэглэгч нь малчид, хөдөө орон нутгийн мал эмнэлэгүүд болно. Үүнийг өөрийн борлуулж буй бүтээгдэхүүний онцлог, хэрэглэгчид зэргээс үзэхэд бэлэн мөнгөний эргэлт нилээд удаан байх төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл малчдын орлого тогтмол биш байдаг компанийг мөнгөн гүйлгээ, хөрвөх чадварын эрсдэлд оруулах магадлалтай. Тиймээс бараа бүтээгдэхүүнээ зээлээр борлуулахаа багасгаж, авлага барагдуулах хугацаагаа богиносгох нь зүйтэй юм.

Бусад эрсдэл /валютын ханш, байгалийн давагдашгүй хүчин зүйлүүд/

Валютын ханшны тогтворгүй байдал нь санхүүгийн тогтвортой байдалд шууд нөлөөлж байна. Үүнээс үүдэн санхүүгийн төлөвлөгөө, төсөлд гэнэтийн алдагдал хүлээх эрсдэл өндөр байна.

Хөрөнгийн суртал нь байгаль цаг уурын нөхцлөөс ихээхэн хамааралтай бөгөөд ган, зуд болон бусад байгалийн гамшигт үзэгдлүүд нь малчдын гар дээрх бэлэн мөнгөний хэмжээ, малын тоог бууруулж улмаар компанийн борлуулалтын хэмжээг бууруулах эрсдэлтэй. Тухайлбал 2000 оны зуд нь манай орны хөдөө аж ахуйн салбарт ихээхэн хохирол учруулсан билээ. Аливаа байгалийн гамшигийн эрсдлийг туулахад малчдын өөрсдийн бэлтгэлээ сайн байгаа хэрэгтэй юм. Харин өвчин эмгэгийн тухайд Бинсэ ХХК нь сургалт сурталчилгаа бэлдэж малчдад хүргэн, эрсдлийг тодорхой хэмжээнд бууруулж байгаа юм. Жишээлбэл “БИНСЭ” ХХК нь өнгөрсөн хугацаанд Монгол орны мал сүрэгт эпидемик өвчин буюу эрдэс бодисоос шалтгаалсан өвчин эмгэгийг малчдад таниулж мэдүүлэх чиглэлийг хөгжүүлэх зорилгоор Боловсрол суваг телевизтэй хамтран сургалт сурталчилгааны олон тооны нэвтрүүлгийг бэлтгэн хүргэсэн байна.

2.7 Үнэт цаасыг андеррайтераар дамжуулан анхдагч зах зээлд худалдахаартөлөвлөж байгаа болуг байгууллагын тухай мэдээлэл

Нэмж гаргаж буй уг хувьцааг хаалттай хүрээнд нэмж гаргах бөгөөд уг үнэт цаасны арилжааг Нэйшнл Сэжуритис ҮЦК ХХК-р дамжуулан хийнэ. Тус компани нь үнэт цаасны зах зээлд дээр Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер Дилерийн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 2006 онд үүсгэн байгуулагдсан. Монголын хөрөнгийн биржийн гишүүн компани юм. Манай компани нь дотоодын компаниудад үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинэ төсөлд хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг Монголын болон Олон улсын хөрөнгийн биржээс санхүүжихэд зөвлөгөө өгч туслахын зэрэгцээ олон улсын болон дотоодын стратегийн түншүүдтэйгээ хамтран компаниудад мэргэжлийн санхүүгийн үйлчилгээг хүргэж харилцагчдынхаа хөрөнгийг өсгөхөд харамгүй туслалцаа үзүүлэхэд бэлэн байна.

Бид байгуулагдсан цагаасаа хойш Техник импорт, Монгол Шевро, Юнигаз, Оллоо, Анод банкинд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг олж өгч байсан арвин туршлагатай. Түүнчлэн Монголын хөрөнгийн бирж дээрээс босгосон хувьцаагаарх хөрөнгө оруулалтын 35 хувийг, бондоорх хөрөнгө оруулалтын 14 хувийг Нэйшнл Сэкиоритис компани зуучлан гүйцэтгэсэн байдаг.

2.8 Үнэт цаасны тухай мэдээлэл, дэлгэрэнгүй танилцуулгатай танилцаж болох газар, цаг, хариуцах ажилтаны нэр, холбоо барих утасны дугаар

Хүснэгт 12. Холбоо барих албан тушаалтны мэдээлэл

№	Нэр	Хаяг, Утас	Харилцах ажилтан
1	Нэйшнл Сэкиоритис ХХК	СБД, 3-р хороо, Усны гудамж-1, Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банкны байр, 14252, 976-9408-1189, www.nationalsecurities.mn	С.Насанжаргал Аналист-Брокер 976-9689-0336 nasanjargal.s@nationalsecurities.mn
2	Бинсэ ХК	ХУД, 2-р хороо Монгол Нэхмэлийн байр 201-203-н тоот, 17032, 11-344740, 976-8801-5051, info@binse.mn	А.Эрдэнэчимэг Няглан бодогч 976-8865-6462

